

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төслийн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж, Хорин долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцах үүрэг бүхий дэд хороо байгуулж болно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт, үндэсний аюулгүй байдал нь эрчим хүчний салбарын тогтвортой байдалтай шууд холбоотой юм.

Сүүлийн жилүүдэд:

- эрчим хүчний хэрэглээ тогтмол өсөх,
- дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадал хүрэлцэхгүй болох,
- импортын эрчим хүчний хамаарал нэмэгдэх,
- сэргээгдэх эрчим хүчний шилжилт эрчимжих,
- томоохон эрчим хүчний төслүүдийн хэрэгжилт удаашрах,
- тариф, санхүүжилтийн бодлого тогтворгүй байх,
- олон улсын техник, технологийн нэвтрэлт, хэрэглээ удаашралтай байх,
- эрчим хүчний салбарын засаглал, хяналт хангалтгүй зэрэг нөхцөл байдал үүсээд байна.

Одоогийн байдлаар эрчим хүчний асуудлыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэж байгаа ч бодлогын уялдаа, урт хугацааны төлөвлөлт, парламентын мэргэшсэн хяналтыг сайжруулахад мэргэшсэн дэд хороо байгуулах шаардлагатай байна.

Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дэргэдэх Эрчим хүчний хөгжлийн дэд хороо нь эрчим хүчний салбарын:

- бодлого,
- хөрөнгө оруулалт,
- үйлдвэрлэл,
- импорт,
- үндэсний аюулгүй байдал,
- ногоон шилжилт,
- бүс нутгийн эрчим хүчний хамтын ажиллагаа,
- тариф болон зах зээлийн шинэчлэл зэрэг асуудлыг дагнан судалж, хууль тогтоох болон хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой юм.

Иймд дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

## **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг тусгана. Үүнд:

1. Эдийн засгийн байнгын хороонд Эрчим хүчний хөгжлийн дэд хороог байгуулах
2. Дэд хороо нь дараах асуудлыг хариуцан холбогдох Байнгын хороогоор уламжлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, эрхэлсэн асуудлаараа тогтоол гаргах эрхтэй ажиллана. Үүнд,
  - эрчим хүчний реформыг тогтвортой хэрэгжүүлэх,
  - эрчим хүчний аюулгүй байдлыг бэхжүүлэх,
  - томоохон төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавих,
  - сэргээгдэх эрчим хүч болон бүс нутгийн эрчим хүчний интеграцид чиглэсэн бодлогын уялдааг хангах,
  - хууль тогтоох үйл ажиллагааны чанар, мэргэшлийг сайжруулахад оршино.

## **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагаврын талаар**

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын хороо нийгэм, эдийн засагт нэн чухал эрчим хүчний асуудлыг илүү мэргэшсэн байдлаар судлан, хэлэлцэх боломж бүрдэнэ.

## **Дөрөв.Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой уялдах талаар**

Энэхүү хуулийн төсөл нь:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль,
- Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль зэрэг хуультай нийцнэ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй. Мөн төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардал үүсгэхгүй бөгөөд парламентын дотоод мэргэшсэн бүтэц, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоход чиглэнэ.